УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22

# Дипломын ажил

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
2017 ОН

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Салбар: Уул уурхай

Мэргэжлийн индекс: 3257-22

# Дипломын ажил

Сэдэв: Бага насны хүүхдүүдийг эрүүл аюулгүй ажиллагаанд төлөвшүүлэх нь

Гүйцэтгэсэн: А.Лханоров ХАБЭА 3А- ангийн оюутан А.Лханоров

Удирдагч: Техникийн ухааны магистр Б.Туяа 98%. А

Зөвлөх багш : Боловсролын ухааны магистр: М.Дэлгэрням

Хамгаалалтанд орохыг зөвшөөрсөн:

Сургалтын албаны менежер: Л. Ганчимэг
Сургалтын арга зүйч: Ц.Мягмарсүрэн

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
2017 ОН

# Агуулга

**УДИРТГАЛ** ....................................................................................................3

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬ ХҮНИЙ ТӨЛӨВШИЛ, ХҮМҮҮЖИЛ ОНОЛ АРГА ЗҮЙ**

1.1 Хүүхдийн төлөвшил, хүмүүжил ..............................................................4

1.2 Хүүхдийн эрхийн тухай хууль ..............................................................13

1.3 MNS 4969:2000 Стандарт .....................................................................19

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ДУНД ТОХИОЛДОЖ БУЙ ОСОЛ БОЛОН ЕБС-Н СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНД ХИЙСЭН СУДАЛГАА**

2.1 Бага насны хүүхдийн дунд тохиолдож буй осол ...........................20

2.2 Багш, эцэг эх, хүүхдүүдээс авсан судалгаа ...................................27

2.3 ЕБС-н бага ангийн сургалтын тогтолцооны өнөөгийн байдал .........32

2.4 ХАБЭА-н сургалтын тогтолцооны гадаадын туршлага ..................43

**ДҮГНЭЛТ** ..........................................................................................................46

**НОМ ЗҮЙ** ..........................................................................................................48

**ХАВСРАЛТ** .......................................................................................................49

**Судалгааны үндэслэл:** Монгол хүн бүр үндсэн хуульд зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах мөн сурч боловсрох эрхтэй гэж заасан байдаг гэвч сүүлийн жилүүдэд бага насны хүүхдүүдийн осолд өртөх тоо нэмэгдэх хандлагатай байна.

**Судалгааны ажлын зорилго:** Монгол хүүхэд бүрийг бага наснаас нь аюулгүй ажиллах арга барилд төлөвшүүлэх.

**Судалгааны ажлын зорилтууд:**

- Эцэг эх, хүүхэд, багш гэсэн гурвалсан асуулга асууж судлах,
- ЕБС-н бага ангийн өнөөгийн сургалтын тогтолцоотой танилцан түүн дээр дүн шинжилгээ хийх
- Санал зөвлөмж гаргах

**Судалгааны ажлын таамаглал:** Тодорхой хичээлийн агуулагаар аюулгүй амьдрах арга ухаанд сургаж байгаа хэдий ч ЕБС-ийн өнөөгийн сургалтын тогтолцоонд ХАБЭА-н бие даасан хичээл сургалтын хөтөлбөрт тусгагдаж өгөөгүй.

**Судалгааны арга:** Энэхүү судалгааны ажлыг боловсруулахдаа анхдагч болон хоёрдогч мэдээлэлийг ашиглан судалгаа шинжилгээ, нэгтгэн дүгнэх, ажиглалт, ярилцлага, асуулгын хуудас бөглүүлэх аргуудыг ашиглан судалсан болно.

**Судалгааны ач холбогдол:** ЕБС-дад MNS 4969:2000 стандартыг хэрэгжүүлж бага насны хүүхдүүдэд аюулгүй ажиллагааг төлөвшүүлсэнээр хүүхэд, эцэг эх, багшийн ажилдаа хандах хандлага сайжирч улмаар ахуйн ослын тоо багасах хандлагатай гэж үзэж байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬ ХҮНИЙ ТӨЛӨВШИЛ БУЮУ ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛ ОНОЛЫН ХЭСЭГ

## 1.1 Хүүхдийн төлөвшил ба хүмүүжил

**"Хүн болох багаасаа"**

**"Буруу өссөн хүүхэд бухын хүзүүнээс хатуу"**

"Хүүхэд хүмүүжлийн дадал хэвшлийн 90 хувийг 5 хүртэлх насандаа, 10 хувийг бусад насандаа эзэмшдэг" **В.А.Сухомлинский**

"Хүүхдийн тархи, сэтгэхүй 2 нас хүртлээ хамгийн эрчимтэй хөгждөг тул энэ наснаас нь хүүхдийг хүмүүжүүлж, зөв иргэн болгож төлөвшүүлэх суурийг тавьж, улмаар хөгжүүлэх шаардлагатай" **Ибука Масару**

Монголчууд: 1. 3...4 настай хүүхдийг хурга, тугал хариулах ажилд сурган, 2. 6...7 насанд нь хурдан морь унуулж, үхэр, адуу хариулуулж, мод, аргал түлш түүх зэрэг ахуйн хөдөлмөрт сургаж, 3. 15...16 насанд нь хөвгүүдийг эмнэг сургах, арьс, шир элдэх, сур боловсруулах, мал услах зэрэг мал маллагааны арга ажиллагаанд бүрэн сургаж, охидыг оёж хатгах, сүү цагаан идээ боловсруулах ажилд дадлагажуулдаг. **Д.И.Майский**

**Хүүхэд хүмүүжүүлнэ** гэдэг нь хэн нэгэний хүсэж буй хэв загварт барьж, тийм сонгодог загварыг бий болгоно гэдэгтэй ижил утгатай. Өөрөөр хэлбэл гурвалжин гадагшаа юм уу? Дотогшоо илүү овойж товойвол гадны хүчээр тайрч, тэгшилж нэг хэвэнд барина гэсэн үг.

**Хүүхдээ төлөвшүүлнэ** гэдэг нь тухайн бодьгал, түүний хувийн шинжийг хүлээн зөвшөөрч, нийгмийн болон ахуйн хүрээнд зөвшөөрөгдсөн хэв маяг болон тогтсон "Соёл"-ын нөлөөлөлөөр оршин тогтнох чадварыг бий болгоно гэж ойлгодог өөрөөр хэлбэл:

1. Суурь соёл: төрөлхийн хувь хүний онцлогыг багтаасан чанар, бусдаас ялгарах хүчтэй илэрхийлэл бүхий хувийн үндсэн шинж

2. Гэр бүлийн соёл: өнгөрсөн болон үзсэн амьдарлын туршлага өөрийн бага насны соёл, гэр бүлийн соёл төдийгүй эцэг эхийн зан заншилыг агуулсан байдаг
3. Нийгэмшилийн нөлөө: нийгмийн харилцаанд оролцох явцад хүүхэд өөрийн гэсэн аливаад хандах хандлагыг олж авна.

Эцэг өвгөд маань хүүхдэд ажил хөдөлмөрийг "Сур, Хий" хэмээн "үүрэгдээд" орхидоггүй байсан. Тэд ажил хөдөлмөрт дадлагажих явцдаа хүүхдийн буруу хийсэн үйлдэл бүрийг **"НҮГЭЛ!"** хэмээх ганц үгээр таслан зогсоож, бусад зүйр үгээр үлгэрлэн аюулгүй ажиллах арга барилыг төлөвшүүлж ирсэн уламжлалтай.

Бага насны монгол хүүхдийн сэтгэл зүйг шинжлэх ухаанчаар судалж гаргасан дүгнэлтэд тулгуурлан амьдрал, ахуйгаа зөв хөтлөх, зөв ажиллах арга барилд сургах, хууль ёсыг дээдлэх, бусдыг энэрэх үзэлд төлөвшүүлэх асуудлыг боловсролын системээр дамжуулан хийх нь үр дүнтэй байх учиртай.

Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн 80-90 хувь нь эцэг эх, гэр бүлийн нөлөөнөөс бий болдог гэж Европын судлаачид үзсэн байдаг. .

Хэдийгээр хүүхдийн оюун ухааны цар хүрээг сургалт хүмүүжлийн ажлаар тэлж өгдөг боловч хүний мөс чанар, сайхан сэтгэл, гаргаж буй зан авир, бие хүний шинжүүд эцэг эхээс хуулбарлагдан бий болдог. Магадгүй та зарим үед хүүхдийнхээ гаргаж буй зан авираас өөрийгөө тольдон хардаг ч байж болох юм.

**Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо**

Хүний хөгжлийн онцгой үе-хүүхэд нас.

Хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах, хариуцлагад сургах, хүүхдийн идэвхтэй оролцоог гэр бүлийн түвшинд хангах, тэдний хүмүүжил төлөвшлийн асуудлыг төрийн бодлогын цөмд байлган хүүхдийн үгийг сонсож, тэдний өмнө

тулгамдаад байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх нийгмийн захиалга, зайлшгүй хэрэгцээ, байна.

Хүнээр хүн хийх уламжлалт арга барилаар үр хүүхдээ зөв хүмүүжүүлэн, төлөвшүүлэх иргэн бүрийн үүрэг, оролцоог ч тодорхойлсон байдаг.

Хүүхдээ зөв хүмүүжүүлэх, нас, бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн хөгжүүлэх нь эцэг эхчүүдийн төдийгүй Монгол төрийн гол бодлого байх учиртай. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилттэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг дэмжих явдал аливаа түвшний шийдвэр гаргагчдаасаа эхлэн байгууллага, хамт олон, эцэг эх, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, ажилтнуудын үндсэн үүрэг байх ёстой.

Өнөөдөр мэргэжлийн байгууллагын судалгаагаар сургуулийн 1000 хүүхэд тутмын нэг нь гудамжинд амьдарч, 750 хүүхэд тутмын нэг нь гэмт хэрэгт холбогдож, 500 хүүхэд тутмын нэг нь халамжийн төвд амьдарч, 26 хүүхэд тутмын нэг нь хөдөлмөр эрхэлж, хоёр хүүхэд тутмын нэг нь сургууль гэр бүлийн орчинд зодуулж, дарамтанд орж байна. Өнгөрсөн онд дээрмийн гэмт хэрэгт 14-18 насны 89 хүүхэд хамрагдсан байна.

Статистикийн мэдээгээр өнөөдөр 0-18 насны хүүхэдтэй 523 мянган гэр бүлд 961 мянган хүүхэд амьдарч байна. Нийт гурваас дээш хүүхэдтэй 104 мянган гэр бүлд 369 мянган хүүхэд, дөрвөөс дээш хүүхэдтэй 32 мянган гэр бүлд 159 мянган хүүхэд амьдарч байна. Улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2009 онд 46 мянгад хүрсний 4683 нь бүтэн өнчин хүүхэд байна. Өрх толгойлсон ээж 82 мянга болж өмнөх оноос 5.8 хувиар өссөн байна.

Нийт 35 мянган хос гэрлэлтээ бүртгүүлж, 2,4 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт өмнөх оныхоос 3,3 хувиар, гэр бүл цуцлалт 27 хувиар өссөн байна.

Энэ мэт сэтгэл эмзэглүүлсэн олон асуудлаас үзэхэд Монгол улсад хүүхэд хамгааллын тогтолцоо, хүүхдээ хөгжүүлэх стратегийн бодлого, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудал ус, агаар мэт хэрэгтэй болоод байна.

Хүүхдийн асуудлаарх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хуулиа хэрэгжүүлж чадахгүй бол хүүхдээ бид хүмүүжүүлж, төлөвшүүлж чадахгүй ээ. Хүүхдийн төлөө ажилладаг, хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хариуцлага сул байна. Хүүхэд хамгааллын өнөөгийн авч байгаа арга хэмжээнүүд нь хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах, хүүхдийн өмнө шинээр үүсч байгаа бэрхшээл, орчин нөхцөлийн өөрчлөлтийн нөлөөнд бий болж буй асуудлыг шийдвэрлэх чадваргүй байна. Хүүхдэд үзүүлж буй эрүүл мэнд боловсролын үйлчилгээний чанар ч муу байна. Хүүхдийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн яамд, агентлагуудын дунд нэгдсэн бодлого, ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

Хүүхэд гэр бүлдээ аюулгүй, амар тайван амьдрах эрх нь зөрчигдөж, олон хүүхэд гудамжинд, асрамж халамжийн газар өсч байна. Хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож, хорих ял эдлэн, хүнд хөдөлмөр эрхэлж, гэр орон, сургууль, цэцэрлэг, асрамж халамжийн төв, гудамж талбай, хорих анги урьдчилан саатуулах байранд, өөрөөр хэлбэл байгаа бүх орчиндоо хүчирхийлэл, дарамт, үл хайрах байдалд өртөх эрсдэлтэй байна

Ирээдүйн иргэдийг багаас нь хүмүүжүүлэн төлөвшүүлэх үйл явц нь тухайн улс орны цаг хугацаа, орон зай, нарийн арга барил, ур чадвар, эв зүй шаарддаг улс үндэстний эрх ашигтай холбоотой амин чухал асуудал байдаг. Хүүхдийг байгаагаар нь хүлээн зөвшөөрч алдааг нь бус амжилт, ахиц өөрчлөлт, эерэг хандлагыг нь урамшуулан хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшлийг цогц байдлаар үнэлэх нь боловсролын байгууллагын өөрчлөлт шинэчлэлтийн үр дүн байх ёстой. Аливаа нийгэмд сургалт нь хүүхэд багачууд өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх бие хүн болгон хөгжүүлэн төлөвшүүлэх, нийгэмшүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Сургалтаар дамжин хүүхэд нийгэмд ажиллаж амьдрах чадвартай, иргэн бие хүн болж, төлөвшдөг.

Хүүхдийн хүмүүжин, төлөвшиж буй хандлага түүнд гарч буй ахиц дэвшлийг үнэлж, энэ явцад эцэг эхийг татан оролцуулах, хэрэгтэй. Хэрхэн яаж үнэлэх нь төвөгтэй асуудал байж болох авч өнөөгийн сурагчийн үнэлгээтэй адилгүй юуны түрүүнд хүмүүжил төлөвшлийг үнэлэх шаардлагатай гэдэг нь боловсролын шинэчлэл дэх амьдралаас ч урган гарч буй тулгамдсан асуудлын нэг мөн. Багш нарт эерэг хүмүүжлийн аргыг эзэмшүүлэх, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудлаар мэргэшсэн нийгмийн ажилнуудыг бэлтгэх, Их дээд сургуулиудын хөтөлбөрт тусгах шаардлага ч байна.

Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудлыг харилцааны хандлагад тулгуурлан сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа, эцэг эхийн дэмжлэг, олон нийтийн оролцоог нягт уялдаатай авч үзэх амьдралын хэрэгцээ байна. Орчин цагийн чанартай боловсролоор дамжуулан хүүхдийг өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээж чаддаг, бие даасан бүтээлч соёлжсон иргэд болгон хүмүүжүүлэх явдал өнөөдөр тулгамдаад байна. Цаашид хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн бодлого, үйл ажиллагааны талаар зайлшгүй авч хэрэгжүүлэх зүйлс.

**Үүнд:**

- Гэр бүл хүүхдийн асуудлаарх тэргүүлэх чиглэлээ зөв эрэмбэлэх, салбар хоорондын үйл ажиллагааг идэвхжүүлэх, удирдлага менежментээ сайжруулах;
- Хүүхдийн эрхийн наад захын стандарт, журмыг тогтоох шаардлагатай байна. Стандарт журам тогтооход хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд чухал үүрэгтэй оролцох;
- Хүүхдийн талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодол, хөгжиж байгаа авьяас чадварыг заавал харгалзан, хүүхдийн бодитой оролцоог дэмжих;
- Хүүхдийн нэр хаягтай байгууллагууд хамтран ажиллаж, хүн хүч, хөрөнгө мөнгөө нэгтгэн ажиллах;
- Олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын механизмыг дэмжин дэлгэрүүлэх;

- Багшийн үйл ажиллагааг хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн үзүүлэлтээр дүгнэдэг болгох;
- Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амрахад зориулсан үйлчилгээний хэлбэрүүдийг өргөжүүлэх;

Хүүхэд залуучуудад зориулсан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн тоо чанарыг дээшлүүлж, тэдний мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх, мэдлэг боловсрол, оюунаа хөгжүүлэх, хүнлэг сэтгэл, зөв хүмүүжил төлөвшилттэй болгоход дэмжих зэргээр бидний ойрын хугацаанд хийж болох олон асуудал байна.

## Хүүхдийн хүмүүжилд багшийн оролцоо

### Багш гэж хэн бэ?

Хүнийг байгаль ба нийгмийн бүтээгдэхүүн гэж үзвэл тэрхүү нийгмийн бүтээгдэхүүн болохынх нь эхийг тавигч нь багш юм. Багш нь хүүхдэд эрдэм номын эхийг зааж, оюун ухааныг нь нээж, бие даан суралцаж ажиллаж амьдрах арга ухаанд сургадаг. Өөрөөр хэлбэл “Багш бол өсвөр залуу үеийнхэнд ажил амьдралдаа хэрэгтэй мэдлэг чадвар туршлага олж авахад нь туслах, тэдний иргэн-бие хүн болж төлөвших, нийгэмших процессийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэдлэг ур чадвар бүхий бие хүн. Ангийн нийт сурагчдын насны онцлог, ой тогтоолт, зан араншин /темперамент/-г харгалзан багшаас сурагчидтай харилцах харилцаа өөр өөр байх хэрэгтэй.

**Багш хүн ямар байх ёстой вэ?** Багш нь хүүхдийг ойлгодог, сургахуйн ухаан сайтай, шудрага зан чанартай, сургах арга барил сайтай байх нь чухал.




**Багш сурагчдын харилцаа Харилцаа нь:** Хамтын үйл ажиллагааны эрэлт хэрэгцээнээс урган гарч байгаа, хүмүүсийн хооронд холбоо хэлхээ тогтоож түүнийгээ цаашид хөгжүүлэхэд чиглэгдсэн олон талт үйл явц юм. Харилцаа нь олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг.

- Нэгтгэх холбох- Хамтын үйл ажиллагааны явцад хүмүүсийг холбож, нэгтгэж өгдөг.
- Төлөвшүүлэх- Багш, эцэг эхийн хоёр талын идэвхитэй харилцаа нь хүүхдийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.
- Солилцох-Багш сурагчдад сурах арга барил эзэмшүүлэхэд энэ харилцаа чухал үүрэгтэй.
- Илэрхийлэх, батлах- Энэ харилцаа нь сурагчид бусаддаа өөрийгөө ойлгуулах, өөрийн авьяас чадварыг батлан харуулах боломжийг нээж нөөц чадвараа хөгжүүлэхэд тус дэм болдог.
- Хүмүүсийн хоорондох харилцаа хандлагыг зохион байгуулах, хадгалах- Багш сурагчдын хооронд зерэг сэтгэгдэл төлөвшүүлэхэд энэ харилцаа нөлөөлдөг. Бусдын талаарх зерэг сэтгэгдэл нь бусадтай тогтоосон

харьцаагаа хадгалах, гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байхад, таагүй сөрөг сэтгэгдэл нь уг харьцааг таслах, саатуулах үйлчилгээтэй байдаг.

- Дотоод харилцаа- Өөртөө хүүрнэн өгүүлэх, өөрийгөө итгэлтэй болгох, өөрийн "дотор хүн"-тэй харилцах үүргийн илрэл юм. Өдөр тутмын үйл ажиллагааны явцад эдгээр харилцааны үүргүүд хамтдаа цогц хэлбэрээр илэрч байдаг.

**Харилцааны саад:** Харилцааны явцад аливаа мэдээлэл гажиж өөрчлөгдөх, зарим үед хүлээн авах ёстой хүнд огт хүрэхгүй байх тохиолдол гардаг.Энэ нь сонсож, хүлээн авч буй хүнийхээ сэтгэл зүйн онцлог тухайн хүнд болон уг сэдэвт хандаж байгаа хандлага, харилцааны нөхцөл зэргээс шалтгаалан мэдээлэл өөрчлөгддөг. Мэдээлэл бүрэн дамжуулах ба хүлээн авах замд тохиолдох сэтгэл зүйн бэрхшээл тотгорыг харилцааны саад гэнэ.

Хүнээр хүн хийх энэхүү мэргэжлийн ажилд тавигдах ёс зүйн шаардлага хамгийн олон шалгууртай, хамгийн хатуу байхаас аргагүй. Тийм ч учраас Ж.Ж.Руссо багшийг "Багш бол муу нөлөөнөөс хүүхдийг хамгаалагч манаач" гэж хэлсэн байдаг. Өөрөө ёс зүйтэй байж гэмээ нь сурагчдадаа гэрэл болно. Багш мэргэжлийн онцлог нь Я.А.Коменскийн хэлснээр бүх урлаг дотроос хамгийн хэцүү нь юм. Учир нь сургалтын үйл явц нь амьд харилцаан дээр суурилсан, оролцогчдоос байнгын тасралтгүй хөгжил, өөрчлөлтийг шаарддаг. Харин өнөөгийн нийгмийн өөрчлөлт, үйлчилгээний байгууллагад тавигдаж байгаа хэрэглэгчийн шаардлагын үүднээс аваад үзвэл багшийн нэр хүнд унаж байгаа нь илэрхий байна. Үүнээс үүдэн багшийн ажил үүргийн нэг салшгүй хэсэг болох түүний ёс зүйн асуудлыг авч үзэх шаардлага боловсролын тулгамдсан асуудал болжээ. Монголчууд ч эртнээс "Шавийн эрдэм багшаас" гэж хэлэлцсээр ирсэн.

**Сурагчдын сурах насны онцлог**

- нярай (0-1 )
- Балчир (1-3)
- Цэцэрлэг (3-7)
- Сургуулийн бага нас (8-10)
- Шилжилтийн нас (12-16)
- Сургуулийн ахлах нас (17-19)

Хүн ам төвлөрөх, хотжих хөдөлгөөний дагуу хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нийгмийн орчны нөлөөч ихэссэн. Эдгээр нөлөөллийг нэгтгэн холбох зохицуулан удирдах явдал сургууль, багш нарын оролцоогүйгээр боломжгүй зүйл юм. Багшийн хөдөлмөр бол зохион байгуулагчийн хөдөлмөр тиймдээ ч бид хүүхдийн хувь заяаг бүрэн хариуцаж байгаагийн хувьд зөвхөн мэдлэг чадвар олгохоос гадна багаас нь тэдний авьяас сонирхол, сайн талыг олж илрүүлэн хөгжүүлж өгснөөр хүүхэд өөртөө итгэлтэй өөрт байгаа давуу талаа олж нээн хөгжүүлэн ирээдүйд зөв хүн болж төлөвшихөд нь ач холбогдлоо өгөх нь зайлшгүй юм.

## 1.2 МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

## ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж**

2.1 Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Хүүхдийн эрхийн зарчим, нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хэрэглэж болно.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ.

3.2.Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

**4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим**

4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.2.төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;

4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

4.1.4.хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;

4.1.5.хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХҮҮХДИЙН ЭРХ, ЭЦЭГ, ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧИЙН ҮҮРЭГ

### 5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх

5.1.Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй бөгөөд хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр зохицуулна.

5.2.Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй.

5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй.

5.4.Хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

5.5.Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга болон түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух, эх орондоо амьдрах эрхтэй.

**6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх**

6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ:

6.1.1.хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших;

6.1.2.хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;

6.1.3.хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах;

6.1.4.хүүхэд шашин шүтэх, эс шүтэх;

6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;

6.1.6.хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх.

6.2.Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдэлнэ.

**7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх**

7.1.Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

7.2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу

зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

7.3.Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

7.4.Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

7.5.Хүүхдийн хамгаалагдах эрхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

**8 дугаар зүйл. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх**

8.1.Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд хүүхэд нийгмийн амьдралд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

8.1.1.хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх;

8.1.2.хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;

8.1.3.хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх;

8.1.4.хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах;

8.1.5.хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах.

**9 дүгээр зүйл. Хүүхдийн хүмүүжил, төлөвшил**

9.1.Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

9.1.1.эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах;

9.1.2.эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;

9.1.3.зохих насанд нь сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол эзэмшүүлэх;

9.1.4.хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх;

9.1.5.эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал, чадвар эзэмшүүлэх;

9.1.6.оюун ухаан, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх.

**10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг**

10.1.Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

10.1.1.хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх;

10.1.2.хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;

10.1.3.хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

10.1.4.хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;

10.1.5.хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;

10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;

10.1.7.хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;

10.1.8.хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах;

10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;

10.1.10.хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах;

10.1.11.хууль тогтоомжид заасан бусад.

10.2.Эцэг, эх тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн 10.1-д заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## 1.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм

### MNS 4969:2000 стандарт

Стандарчлал хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 105 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Хамрах хүрээ

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг сургуулийн өмнөх насны хүүхэд, бүх шатны сургуулийн сурагчид, шинээр давтан, хоёр дахь мэргэжлээр бэлтгэгдэж байгаа ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, инженер, техникийн болон удирдах ажилтанд зориулж, шат шатанд зохион байгуулна.

### 2. Үндсэн дүрэм

Боловсролын түвшинд

2.1 Цэцэрлэгийн насны хүүхэд-Тоглоом, наадгай, ахуйн хэрэгсэлтэй нь холбож осол, аюулын талаар ойлголт өгч зөв буруут ялгах чадвар олгох, ариун цэвэр эрүүл ахуйн анхны хэвшлийг төлөвшүүлэхэд анхаарч сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.

2.2 Бага боловсрол эзэмшиж буй сурагчдад-аливаа аюултай, хортойүзэгдэл юмс, эрүүл ахуйн талаар анхан шатны мэдлэг олгоно.

2.3 Суурь боловсрол эзэмшиж буй сурагчдад-хортой үзэгдэл юмсын талаар шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлж бие даан аюулгүй ажиллах дадлыг олгоно.

2.4 Бүрэн дунд боловсрол эзэмшиж буй сурагчдад-хими, физик, биологийн аюултай ба хортой хүчин зүйлийн талаарх ойлголт, бие даан аюулгүй ажиллах арга барилд сургах чадвар олгоно.

2.5 Их, дээд сургууль, коллежи болон үйлдвэр технологи, АУ-ны чиглэлээр суралцаж буй оюутнуудад ХААЭА-н онолын үндсийг эзэмшүүлж, бусдад зааварчлах чадвар эзэмшүүлнэ.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ДУНД ТОХИОЛДОЖ БУЙ ОСОЛ БОЛОН ЕБС-Н СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНД ХИЙСЭН СУДАЛГАА

## 2.1 БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ДУНД ТОХИОЛДОЖ БУЙ ОСОЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүүхдийн осол гэмтлийн талаархи судалгааны тайланд дурьдсанаар 2002 онд 875000 хүүхэд, 2004 онд 950000 хүүхэд осол гэмтэл, хүчирхийллийн улмаас нас барсны 90 хувь нь санамсаргүй осол гэмтлээс шалтгаалан нас барсан байна.

Манай оронд хүүхэд өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгааны дөрөвдүгээрт гэмтэл хордлого ба гадны шалтгаант үр дагавар орж байна.

2009 оны байдлаар Монгол улсад 0-5 насны хүүхдийн эндэгдлийн 9.2 хувийг осол гэмтэл, гадны шалтгаант үр дагавар эзэлсэн байна. Хүүхдийн дунд тохиолдох осол гэмтэл жил тутам өсөн нэмэгдэж, 2015 он гэхэд 1 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн нас баралт хамгийн өндөр буюу 10 000 хүүхэд тутамд 19.4, харин 1-4 насанд 5.1 хүүхэд нас барах төлөвтэй байна.

### 2.1.1 ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ

Улсын хэмжээнд 2015 оны Замын цагдаагийн газрын мэдээгээр 0-16 насны нийт 564 хүүхэд зам тээврийн осолд өртсөнөөс 36 нь нас барсан байна. Насаар нь авч үзвэл, 0-6 насных 16,3 хувь, 7-16 насных 83,4 хувийг эзэлж байгаа аж. 2011-2014 оны эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр Монгол Улсад зам тээврийн ослоос болж өдөр бүр 1-2, сард дунджаар 44, жилд 530 хүн амь насаа алдаж байна гэсэн тооцоо гарч байсан ч осол хэргийн тоо жилээс жилд өссөөр байна. Өнгөрсөн онд зам тээврийн ослын улмаас 53 хүн амиа алдаж байсан бол 2015 оны эхний улиралд 58 хүн нас барсан байна. Энэ онд 148, өнгөрсөн жил 166 хүн зам тээврийн ослын улмаас гэмтэж бэртсэн байна.

Манай орны хувьд бага насны хүүхдүүд зам тээврийн осолд өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна. 2013 оны 10 дугаар сарын байдлаар 994 хүүхэд зам тээврийн осолд өртснөөс 31хүүхэд авто ослын улмаас амь насаа алдсан ба

Улсын хэмжээнд 2008 онд 622 зам тээврийн осол бүртгэгдсэн. Харин 2009 онд 564 болж буурсан. Хэдийгээр 9,3 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа ч хүүхэд зам тээврийн улмаас нас барах нь өссөн байна. 2008 онд 31 хүүхэд зам тээврийн ослоос нас барсан бол 2009 онд 36 болж 16,1 хувиар өсчээ.

Хүүхэд зам тээврийн осолд өртөж байгаа шалтгааныг авч үзвэл Нийслэлийн хэмжээнд явган зорчигчийн буруугаас 74,6, жолоочийн буруугаас 16,3, эцэг эх, асран хамгаалагчийн буруугаас болж 9,1 хувь нь гарчээ гэсэн үзүүлэлттэй байна. Харин энэ үзүүлэлт нь орон нутагт арай өөр.

Явган зорчигчийн буруугаас 8,2, жолоочийн буруугаас 89, эцэг эхийн буруугаас 2,8 хувь нь гарчээ гэсэн стасистик гарсан. Нийслэлд явган зорчигч хүүхдүүд осолд өртөх нь их байдаг. Харин орон нутагт тээврийн хэрэгсэлд зорчигч болж яваад гэмтэх нь их. Өөрөөр хэлбэл, автомашинд явж байгаад гэмтсэн, нас барсан тохиолдол элбэг байдаг.

**Зам тээврийн Статистик мэдээлэл**

Зам тээврийн осолд өртөж гэмтэж нас барсан хүүхдүүдийн насны байдлыг авч үзвэл 0-6 16,3 хувь 7-14 насны хүүхдүүд 58,4 хувийг, 15-16 насны хүүхдүүд 25 хувийг эзэлж байна.

Эндээс юу харагдаж байна гэхээр замын хөдөлгөөнд бие даан оролцож байгаа хүүхдүүд осолд их өртөж байна. Өөрөөр хэлбэл, бага болон дунд ангийн хүүхдүүд зам тээврийн осолд өртөх нь түгээмэл.

Мөн зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг цаг каригаар нь гаргаж байгаа. Сүүлийн хоёр жилээр авч үзвэл хичээл эхлэх, тарах цагуудад зам тээврийн осолд өртөх нь элбэг. Тухайлбал, өглөө 07-08, өдөр 11-13, орой 16-18 цагт илүү их өртөж байгаа. Мөн гаригаар нь гаргасан судалгаа байдаг. Амралтын өдрүүдэд хүүхэд өртсөн тохиолдол бараг байдаггүй. Ажлын өдрүүд буюу даваагаас баасан гаригуудад 83 хувь нь гарсан байна.

2009 онд Улсын хэмжээнд 9129 зам тээврийн осол гарсны 7065 нь нийслэлд гарсан байна. 2010 онд Улсын хэмжээнд 8809 зам тээврийн осол бүртгэгдсэн 6879 нь нийслэлд гарсан байна. 2010-2015 онд гарсан 3542 зам

тээврийн осол гарч, 3588 хүүхэд бэртэж 68 хүүхэд нас барсан байна. Үүнийг оноор нь авч үзвэл:

График.1 Улсын хэмжээнд 2010-2015 онд гарсан зам тээврийн осол




- 2010 онд зам тээврийн ослын улмаас 541 хүүхэд гэмтэж, 16 хүүхэд нас барсан.
- 2011 онд 798 хүүхэд гэмтэж, 16 хүүхэд нас барсан.
- 2012 онд 720 хүүхэд гэмтэж, есөн хүүхэд нас барсан.
- 2013 онд 548 хүүхэд гэмтэж, 10 хүүхэд нас барсан.
- 2014 онд 484 хүүхэд гэмтэж, найман хүүхэд нас барсан.
- 2015 онд 514 гэмтэж, есөн хүүхэд нас барсан байна.

Зам тээврийн ослоор сүүлийн хоёр жил нийт 637 хүн нас барсан байна. Харин энэ оны эхний улиралд 58 хүн зам тээврийн ослоор нас баржээ.

График 2. Говьсүмбэр аймгийн хэмжээнд бага насны хүүхэд өртсөн гэмт хэрэг болон осол.




Үүнээс хархад зам тээврийн осол 2015 онд 1, 2016 онд 2, 2017 онд 2 гарсан ба 2017 оны ослоор 14 настай 1, 10 настай 1 хүүхэд нас барсан байна.

Дан ганц зам тээврийн осол гэлтгүй бусад осол, гэмт хэрэгт бага насны хүүхэд багагүй өртдөг нь харагдлаа.

## 2.1.2 ТҮЛЭГДЭЛТ

Манай улсын осол гэмтлийн нийт нас баралтын 13 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтэл эзэлж байна. Бага насны хүүхдийн осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны нэг түлэгдэлт өвчин болоод байна. 2016 оны байдлаар Гэмтлийн эмнэлэгт түлэгдэлтээр нийт 4059 үйлчлүүлэгч түлэгдлийн улмаас яаралтай тусламж авсны 62.2 хувь буюу (2525 ) нь 5 хүртэлх насны хүүхдүүд байна. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2016 оны тоо мэдээгээр 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт нийт нас баралтын 14.4 хувийг эзэлж байгаа бөгөөд түүний 76.5 хувь нь түлэгдсэн_шалтгаанаар нас барсан байна. Түлэгдсэн шалтгаанаар нас барсан хүүхдүүдийн 77 хувь нь халуун хоол цайнд, 23 хувь халуун усанд түлэгдсэн ба дийлэнх хувь нь биеийн олон хэсгийн 3-р зэргийн түлэгдэлттэй байна.

График.3 Түлэгдэлтийн нас баралт




Бага насны хүүхэд түлэгдэхэд түлэгдлийн талбай нь бага ч бие мах бодь, арьсны физиологийн бүтцийн онцлогоос шалтгаалан гүн түлэгддэг учир зайлшгүй эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, улмаар насан туршид хөгжлийн бэрхшээлтэй болох эрүүл мэнд, гоо сайхан, сэтгэл зүйгээрээ хохирч ирээдүйд идэвхигүй амьдралтай болдог тул уг гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдлийн өвчлөл, нас баралт, түүнээс шалтгаалсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо буурахгүй байгаа ба энэ асуудалд зөвхөн эрүүл мэндийн байгууллагууд бус төр, хувийн хэвшлийн байгууллагууд нэн ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтийн анхаарлыг хандуулахад хамтын ажиллагаа оролцоо чухал байгааг харуулж байна.

0-5 насны хүүхдийн осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны нэг нь түлэгдэлт өвчин болоод байгаа. Тодруулбал, зөвхөн 2012 онд л гэхэд Гэмтлийн эмнэлэгт түлэгдэлтээр хандсан 1241 өвчтөнөөс 851 тохиолдол нь (69%) буюу талаас илүү хувь нь зөвхөн 0-4 насны хүүхдүүд байсан байна.

Улаанбаатар хотод 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн өвчлөл, нас баралт болон тахир дутуу бологсдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа аж. Тиймээс түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх асуудалд зөвхөн эрүүл мэндийн байгууллагууд бус төрийн болоод хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа оролцоо нэн чухал байна гэдгийг эмч нар ярьж байна.

Иймд түлэгдэлтэнд өртөж буй өндөр эрсдэлтэй бүлэг болох 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийг бууруулахын тулд эцэг эхчүүд, асран хамгаалагчдын анхаарал болгоомжлолыг нэн тэргүүнд нэмэгдүүлэх шаардлагатай байна.

0-5 хүртэлх насны хүүхдэд тохиолдож байгаа нийт осол гэмтлийн нэгдүгээрт халуун ба химийн үйлчлэлээр түлэгдсэний улмаас эмнэлэгт хандсан тохиолдол тэргүүлж байна.

Энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх болон анхны тусламжийг зөв зохистой үзүүлэх мэдлэг, чадварыг сайжруулах хэрэгцээтэй байгаа юм байна.

Ер нь түлэгдэлтийн шалтгааныг авч үзвэл халуун хоол цайнд түлэгдсэн тохиолдол нийт шалтгааны 47-52.2 хувийг эзлэж байгаа бөгөөд бага насны хүүхэд аюултай нөхцлийг бүрэн гүйцэд ухамсарлах чадвар хязгаарлагдмал, эсрэг хариу урвалыг гүйцэд хурдан үзүүлж чаддаггүйгээс аливаа аюулд илүүтэй өртөж үүний

улмаас нас барах, тахир дутуу болох, өвчлөх тоо жилээс жилд нэмэгдэж байгаа талаар дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлсэн байна.

График.4 Түлэгдэлтийн шалтгаан




Гэрийн зууханд тусгаарлалт байхгүйгээс хүүхдүүд халуун яндан, зууханд хүрдэг. Мөн тогоо, халуун тогоо, ус буцалгагч, халуун сав, будаа агшаагч зэрэг халуун хоол, цайтай сав, суулгыг тавих тусгай тавиур байхгүйгээс шалан дээр байршуулж байна. Энэ нь бага насны хүүхдүүдэд шууд түлэгдэх аюултай орчинг бий болгож байна.

График 5. Говьсүмбэр аймгийн хэмжээнд бага насны хүүхдийн дунд гарсан түлэгдэлтийн осол



Говьсүмбэр аймгийн хэмжээнд зохион байгуулдаг ахуйн осол болон гэмт хэргээс урьдчилан сэргийлж дараах сургалт үйл ажиллагааг явуулдаг байна.

- Гэмт хэрэг, аюулгүй ажиллагааны сургалт сард /1-2/ удаа.
- Өсвөрийн цагдаа /2013 он/
- “School police” Аймгийн иргэдийн хурлын тогтоолоор шийдсэн. /2015 он/
- ЕБС-н бага ангийн дунд “Ногоон гэрэл, цагаан шугам”. /11 сард/
- СӨБ-д “Замын хөдөлгөөний цагаан толгой”. /4 сард/
- Зам тээврийн осолд өртсөн хүүхдийг хүндэтгэх өдөр. /3 сард/

## 2.2 БАГШ, ЭЦЭГ ЭХ, ХҮҮХДҮҮДЭЭС АВСАН СУДАЛГАА

Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн бага ангиийн сургалтын тогтолцооны өнөөгийн байдалтай танилцахаас өмнө нь багш, эцэг эх, хүүхэд гэсэн бүтцээс бүтсэн асуулга хариултыг явуулах нь зүйтэй болов уу? хэмээн бодож нийт 20 багш, 30 эцэг эх, бага ангийн болон цэцэрлэгийн насны 30-н хүүхэд-с дараах асуулга судалгааг авлаа .

### Багшаас асуух асуулга

Хүснэгт 1. Асуулга 1

| Асуулга | Хариулт |
|---|---|
| 1. Та аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэр сайн мэдэх вэ? | А. Мэднэ- 10%<br>Б. Мэдэхгүй- 60%<br>В. Бага зэрэг- 30% |
| 2. Таны бодлоор бага насны хүүхэд аюулд өртөх тохиолдол хэр их байдаг вэ? | А. Маш их -60%<br>Б. Их -40%<br>В. Бага -0% |
| 3. Та эрүүл аюулгүй байдлын талаар хичээл ордог уу? /үгүй бол яагаад?/ | А. Тийм - 10%<br>Б. Үгүй – 90%<br>Энэ нь сургалтын тогтолцоонд тусгагдаагүй |
| 4. Аюулгүй байдлын хичээлээ ямар байдлаар ордог вэ? /сургалтын хэлбэр/ | А. Ярилцлага- 90%<br>Б. Хөгжөөнт тоглоомоор-10% |
| 5. Ямар хичээл дээр энэ талаар түлхүү ордог вэ? | Хүн байгаль, Хүн нийгэм |
| 6. Та хичээлээ өдөр бүр ордог уу? | А. Тийм- 35%<br>Б. Үгүй – 65% |

Энэхүү судалгаанаас харахад бага насны хүүхэд аюул, эрсдэлд өртөх өндөр магадлалтай байдаг бөгөөд эрүүл орчин, аюулгүй ажиллагаа гэдэг ухагдахуунд /суралцсан/ суралцаж байгаа эсэх нь тодорхой бус байна.

**Эцэг эхчүүдээс асуух асуумж**

Хүснэгт 2. Асуулга 2

| Асуулга | Хариулт |
|---|---|
| 1. Та хэдэн хүүхэдтэй вэ? | /1-2/ хүүхэдтэй |
| 2. Таны хүүхэд хэдэн настай вэ?. | /3-8/ настай |
| 3. Та хүүхдийнхээ багштай хэр сайн харилцаатай вэ? | А. Сайн- 77%<br>Б. Дунд- 20%<br>В. Муу-3% |
| 4. Танай гэрээс танай хүүхдийн цэцэрлэг, сургууль хүртэлх хэр их эрсдэл байж болох вэ? /машин зам, гүүр, гол, ус, ШТС г.м/ | А. Эрсдэл ихтэй- 63%<br>Б. Эрсдэл багатай- 27% |
| 5. Та бага насны хүүхдээ аюултай эрсдэлтэй зүйлсээс хамгаалахын тулд ямар арга хэрглэдэг вэ? | А. Зааж зөвлөх- 50%<br>Б. Байнгын хараа хяналттай байлгах 50% |
| 6.Та хүүхдээ хараа хяналтгүй орхидог уу? | А. Тийм-0%<br>Б.Үгүй- 90%<br>В. Зарим тохиолдолд- 10% |
| 7. Та аюултай, эрсдэлтэй зүйлсийг хүүхэддээ хэрхэн ойлгуулдаг вэ? | А. Ярилцах- 40%<br>Б. зааж өгөх- 37%<br>В. эрсдэлийг өөрийн биеэр үзүүлэх- 23% |
| 8. Таны хүүхэд өмнө нь ахуйн осолд өртөж байсан уу? | А. Тийм- 45%<br>Б. Үгүй – 55% |
| 9. Та хүүхэддээ хэр их цаг зав гаргадаг вэ? | А. Сайн- 28%<br>Б. Муу-16%<br>В. Дунд- 56% |

Энэхүү судалгаанаас хархад бага насны хүүхдийг эцэг эх нь хараа хяналтгүй орхидоггүй бөгөөд аль болох аюул, эрсдэлээс хол байлгах, өөрсдийн мэдэх зүйлсээ зааж сургах арга хэмжээг авдаг ч хүүхэддээ тодорхой хугацааг гаргаж чададгүй нь мөн л эрсдэлтэй юм.

**Бага насны хүүхдүүдээс авах ярилцлага, асуулга**

1. Танай гэр танай сургуулиас хэр хол вэ?
2. Хичээлээс тархад нь ээж аав нь ирж авдаг уу?
3. Хичээл нь хэдэн цагаас тардаг вэ?
4. Чиний хувьд аюултай зүйл гэж юу вэ?
5. Найз чинь гүйж байгаад бүдрээд уначихвал чи яаж туслах вэ?

**Асуулгын хариулт**

График 6. Хүүхдүүдээс асуух асуулга 1, 2-ын асуултын хариултыг графикаар харуулав.







3, сургуулийн насны хүүхдүүдийн хичээл нь өглөө ордог бөгөөд өдөр 13:30-иас 14:00 цагийн хооронд тардаг байна. Харин цэцэрлэгийн насныхан орой 17:00 цагт тардаг байна.

2 Хүүхдүүдийн хувьд аймар юм бол аюултай зүйл

3 Найз нь явж байгаад бүдэрч унаад хөлөө шалбалвал яах вэ? Гэсэн асуултанд юм нааж өгнө буюу лент нааж өгнө гэсэн маш хөөрхөн эвлэгхэн хариулт авлаа.

Хүүхэд өсөхийн хэрээр эцэг эхийн хараа хяналт сулардаг бололтой гэвч энэ нь нэг талаараа хүүхдээ бие хүн болгон төлөвшүүлж буй хэрэг юм. 5-р асуулгын хариултыг хархад тэднийг огт аюулгүй ажиллагааны талаар мэдэдгүй гэж хэлж болохгүй юм.

## 2.3 ЕБС-Д ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ СУРГАЛТ БОЛОН ХӨТӨЛБӨР

**ЕБС-н (1-5)-р ангид ордог хичээлүүд**

- Математик
- Монгол хэл
- Хүн байгаль
- Хүн орчин
- Хүн нийгэм
- Дүрслэх урлаг

ЕБС-н (1-5)-р ангид дээрх хичээлүүд ордог бөгөөд үүнд эрүүл аюулгүй ажиллагаа гэх хичээл ордоггүй ба “хүн орчин”, “хүн байгаль” гэх хичээлүүдээр бага насны хүүхдэд ихэвчдэн дэг журам , тэмдэг тэмдгэлгээгээр дамжуулан эрүүл мэнд, замын хөдөлгөөнд хэрхэн оролцох, хүн болж төлөвших зэрэг хүүхдийн хандлага талаас нь хүмүүжүүлхэд чигэлсэн хичээлээр хичээлэлдэг байна.

Зураг 2. III-р ангид ордог “Хүн Орчин” хичээлийн агуулга






### 2.3.1 ЕБС-Н СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨР

БСШУ–ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 10–ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан "**Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр**"–т тусгагдсан дараах санаануудыг хүүхдийг ХАБЭА–д төлөвшүүлэх талаарх санаа гэж ойлгож байна. Үүнд:

**"Нийтлэг үндэслэл"–д:**

"Мэдлэгт суурилсан нийгэм, мэдээлэл харилцааны технологийн хурдацтай хөгжлийн энэ эрин үед хүүхдийг бага наснаас нь янз бүрийн мэдлэг эзэмшүүлэх гэхээс илүүтэй тэдний төрөлхийн суралцах хүсэл эрмэлзэл, дур сонирхол, баяр баясгаланг хадгалан батжуулах, тэдэнд орчинтойгоо идэвхтэй харьцаж, өөрөө судлан шинжилж учир холбогдлыг нь олж нээх боломж олгох, **өөрийгөө хариуцан авч явах чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.**";

"Монголчууд хүүхдээ сайн хүн болгон төлөвшүүлэх уламжлалт сэтгэлгээ, ёс заншилтай ард түмэн. Эцэг эхчүүд хүүхэддээ багаас нь эрдэнэт хүний биеийн үнэ цэнэ, нүгэл буян, үйлийн үрийн сургаал, бусдын энэрэн нигүүлсэх, хайрлан халамжлах, байгаль дэлхийтэйгээ зөв харьцах арга ухаан, эцэг эх, ахмадыг хүндэтгэх, ач тусыг нь санахыг ухааруулан сургасаар ирсэн. Энэхүү уламжлалт арга ухаанаа эрхэмлэн **хүүхэд бүрийн хүн болох төлөвшилд илүү анхаарах** нь өнөөгийн нийгэм, хөгжлийн хэрэгцээ, шаардлага болоод байна.

**Сургалтын цөм хөтөлбөрийн зорилт"–д:**

Биеийн болон гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах, **эрүүл амьдрах дадал хэвшил эзэмших, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх чадварт суралцах**".

Хүснэгт 3. Сургалтын цөм хөтөлбөрийн чиглэл

| Сургалтын чиглэл | Ерөнхий чадвар | Тусгай чадвар | Агуулгын тогтолцоо бүрэлдхүүн хэсэг |
|---|---|---|---|
| Хөдөлгөөн эрүүл, мэнд | -Хөдөлгөөнөө удирдан зохицуулах<br>-эрүүл амьдрах дадал хэвшилтэй болох | -Гэмтэхээс болгоомжлох, өвчлөлөөс сэргийлэх | -эрүүл ахуйн дадал хэвшил |
| Зан чанар харилцаа | Эерэг зан чанартай, бусадтай амархан харилцах | -дүрэм журамыг ойлгож мөрдөх | -бусдад тавих анхаарал, хайр<br>-хариуцлага харилцааны хэм |

Цөм хөтөлбөрт тусгагдсан дээрх чадваруудыг ямар хичээлээр олгож байгаа талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газраас өгсөн “Оюутан сурагчдад аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн суурь мэдлэг олгох, эзэмшүүлэх талаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгагдсан талаарх товч мэдээлэл”–ийг үзье (2016 оны 4–р сар).

1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрт бага насны хүүхдэд эрүүл амьдрах дадал хэвших эзэмших, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх чадвар тусган хэрэгжүүлж байна.

2. ЕБС–ийн 1-5 дугаар ангид судалдаг бүх хичээлийн агуулгад аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн суурь мэдлэг олгох чадваруудыг тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн:

- “Хүн орчин” хичээл (цөм хөтөлбөрийн 50–р хуудас)–д “Хичээлийн хэрэглэлээ бэлтгэх, хаана юуг, хэзээ хэрэглэх, зөв сонгохоо төлөвлөх, энгийн багаж хэрэгсэл ашиглан хэмжих, турших, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах”

- "Хүн ба байгаль" хичээл (цөм хөтөлбөрийн 59–р хуудас)–д "Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх"
- "Урлаг" хичээл (цөм хөтөлбөрийн 74–р хуудас)–д "Аюулгүй ажиллагааны дүрэм, тэмдэг тэмдэглэгээг тайлбарлах"
- "Биеийн тамир" хичээл (цөм хөтөлбөрийн 85–р хуудас)–д "Дасгал хийх аюулгүй ажиллагааны заавар, заал талбайд тогтоосон дэг мөрдөх, тоглоомын дүрэм баримтлах",

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа (цөм хөтөлбөрийн 122–р хуудас)–д "Үйлдвэрлэгчийн аюулгүй ажиллагааны заавартай танилцах" гэх мэт

**ЕБС-н бага ангид ордог хичээлийн агуулга**

Хүснэгт 5. ЕБС-н бага ангид ордог хичээлийн агуулга

| Хүн ба орчин | Иргэний боловсрол |
|---|---|
| 1-р анги<br>Тоглоом тоглох ба эрүүл ахуйн дэглэм сахих | 1-3-р анги<br>Сайн үйлийг хэвшүүлэх, зөв хооллох, идээ ундааг тохируулан хэрэглэхэд суралцах, тогтоосон дэгийг мөрдөж хэвших |
| 2-р анги<br>Уламжлалт болон орчин үеийн тоглоомоос сонгож тоглох эрүүл ахуйн дэглэм сахих | 4-5-р анги<br>Дэг болон дүрмийг мөрдөж хэвших, өтгөс нялхасыг асран халамжлахыг эрхэмлэх, зан заншилаа эрхэмлэх, суралцах, хэвшүүлэх |
| 3-р анги<br>Тоглоомоо цэвэр ариг гамтай, эмх цэгцтэй байлгах, хэрэглэх, гараа угаах | |

3. ЕБС–ийн 6...9 дүгээр ангид судалдаг бүх хичээлийн агуулгад аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн суурь мэдлэг олгох чадваруудыг тусган мөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн:

- "Байгалийн ухаан" хичээл (цөм хөтөлбөрийн 58, 76–р хуудас)–д "Ажиглалт туршилтын үед хэрэглэх багаж хэрэгслийг нэрлэж сонгох, аюулгүй ажиллагааны талаар эргэцүүлэн бодох, гүйцэтгэх", "Ажиглалт, туршилт гүйцэтгэх явцдаа өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг баримтлах",
- "Дизайн, технологи" хичээл (цөм хөтөлбөрийн 104, 108–р хуудас)–д "Гар багажийн аюулгүй ажиллагаа, гар багаж хэрэгсэл ашиглан материал боловсруулах болон гар ажиллагаагаар хийх хялбар схем зургийг унших, тайлбарлах, материал боловсруулах арга барил, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх" гэх мэт.

4. ЕБС–ийн 1...12 дугаар ангид судалдаг "Биеийн тамир", "Эрүүл мэнд" хичээлийн агуулгад эрүүл мэндийн суурь мэдлэг чадвар олгох агуулгуудыг тусган хэрэгжүүлж байна.

Хүний хариуцлагатай байх зарчмыг бага наснаас нь төлөвшүүлэх шаардлага маш чухал. Манайд эрүүл мэндийн боловсролын талаар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, эрүүл мэндийн боловсрол, анагаах ухааны чиглэлээр 2003–2006 онд хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУ болон Эрүүл мэндийн сайдын 2003 оны 188/143 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлсний үр дүнд ерөнхий боловсролын сургууль (ЕБС)–ийн суралцагчдад эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр бодлогын хүрээнд дараах эрх зүйн баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байна. Үүнд:

1. 1998–1999 оны хичээлийн жилээс ЕБС-д эрүүл мэндийн хичээл анх албан ёсоор орох болсон;

2. 2002–2003 оны хичээлийн жилээс ЕБС–ийн нийт суралцагч жил бүр34–36 цагийн эрүүл мэндийн хичээл судлах болсон;

3 .2004 онд Эрүүл мэндийн боловсролын стандарт батлагдсан;

4.Багш нар стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсон;

5 .ЕБС–ийн анги бүрт судлах сурагчийн сурах бичгүүд, бусад сургалтын хэрэглэгдэхүүн хэвлэгдэн гарсан;

6. МУБИС, түүний харьяа сургуулиудад эрүүл мэндийн багш бэлтгэх асуудлыг институтчилж, эрүүл мэндийн багшийн хавсарсан анги нээсэн.

Монгол улсын стандарт MNS4969:2000 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" юм. Энэхүү стандартад "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг сургуулийн өмнөх насны хүүхэд, бүх шатны сургуулийн суралцагчид , шинээр давтан, хоёр дахь мэргэжлээр бэлтгэгдэж байгаа болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан, инженер, техникийн болон удирдах ажилтанд зориулж, шат шатанд нь зохион байгуулна" хэмээн заажээ.

Манай улсын ЕБС–ийн эрүүл мэндийн сургалт, ОХУ–ын дунд сургуулиудын ХАБЭА–н сургалтын бодит байдал дээр дурдсанчлан байхад MNS4969:2000 стандартын хэрэгжилт, өөрөөр хэлбэл аюулгүй байдлын талаарх сургалт бага насны хүүхдүүд, дунд сургуулийн хүүхдүүдийг хамарч чадаж байгаа эсэхэд анхаарал хандуулах шаардлага зүй ёсных болжээ.

Мөн нэг чухал баримт бичиг бол 2013оны 8дугаар сарын 16–ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар баталсан "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрийг 2013–2014 (туршилтын үе шат), 2014–2016 (үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үе шат) онуудад 2 үе шаттай хэрэгжүүлэхээр заасан.

Тус хөтөлбөрийн **"Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл" дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа"** бүлэгт "6.1.4. хүмүүнлэг, ардчилсан нийгмийн иргэнд зайлшгүй төлөвшсөн байх чадамжид суурилан нэн тэргүүнд монгол хэл, математик, байгалийн ухааны стандартыг боловсруулна. Ахлах ангийн сургалтын хөтөлбөр уян хатан, хувилбартай байна" хэмээн заажээ.

## 2.3.2 "ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД" ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт: "... эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн "Зөв монгол хүүхэд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.", "ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлого баримтлан, үндэсний шинэ стандарт нэвтрүүлнэ" гэж тус тус заасан.

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн эрин үе нь нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадварыг хүн бүрээс шаардаж байгаагаас дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинэ зуунд хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг чадвартай, бүтээлч, хариуцлагатай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлж байна.

Иймээс монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгож төлөвшүүлэхорчныг бүрдүүлэхэд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлон "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөр 2013.08.16 ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар батлагдсан.

"Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөрийг "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл", "Авьяас", "Ном" гэсэн гурван дэд хөтөлбөрийн хүрээнд 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

**1. "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл" дэд хөтөлбөрт**

- Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах
- Багш бэлтгэх болон багшийн тасралтгүй хөгжлийн тогтолцоог бий болгох
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй, технологийг нэвтрүүлэх
- Боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох

- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сурах бичгийн стандартыг шинэчлэн боловсронгуй болгох
- Боловсролын бүх шатны байгууллагыг чадавхжуулан байгууллага, хамт олон, ажилтны бие даасан бүтээлч үйл ажиллагааг дэмжих гэсэн өөр хоорондоо уялдаа холбоо бүхий багц асуудлыг авч үзэж байгаа болно.

## 2. "Авьяас" дэд хөтөлбөрийн хүрээнд:

- Монгол хүүхдийг хөгжлийн суурь судалгааг хийж, хөгжлийн шалгуур үзүүлэлтийг гаргах
- Хүүхдийн авьяасыг бүх талаар нээх, хөгжүүлэх, амжилтад хүргэх арга зүйг боловсруулж, түгээх
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж багш, эцэг эх, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлнэ.

Бага наснаас нь хүүхэд бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлснээр ирээдүйн ажил, мэргэжлээ зөв сонгох, эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй хөдөлмөрлөх цогц мэдлэг, чадвартай иргэн болж төлөвших нөхцөл боломцоог бүрдүүлэх юм.

## 3. "Ном" дэд хөтөлбөрийн хүрээнд

- Номыг бүтээлчээр унших соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн ном зохиох, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг дэмжих зэрэг зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

## 2.3.3 ЕБС-Д ЯВАГДАЖ БУЙ ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1990-д оноос өмнө ЕБС-д иргэний хамгаалалтын хичээл орж түүхэн үүргээ нэлээд сайн гүйцэтгэж байсан гэж үздэг. 90-иэд оноос хойш сургалтынхаа агуулгыг цаг үетэйгээ холбон өөрчилж чадаагүй, эрх зүйн орчин ч дутагдалтай байснаас ЕБС-н сургалтаас иргэний хамгаалалтын хичээл хасагдсан байдаг.

Харин 2003 онд Монгол улсын их хурлаар баталсан гамшгаас хамгаалах тухай хуульд "оюутан, сурагчдын гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг тухайн сургалтыг тухайн сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасны үндсэн дээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах" гэж заасан байдаг.

Хуулийн энэ заалтыг өнөөг хүртэл БСШУСЯ, ОБЕГ олигтой хэрэгжүүлж чадаагүй байна. Үндсэн шалтгааныг шинжлэн үзэхэд, тухайн үед ЕБС-н байгууллагад хийгдэж буй сургалтын өөрчлөлт, шинчлэлийн хүрээнд гамшигаас хамгаалах хичээлийн хөтөлбөр, сургалтын агуулагын хүрээ, стандартыг боловсруулан батлуулж чадаагүйтэй холбоотой гэж үзэх үндэслэл байна. Хамгийн гол нь байгууллага хоорондын харилцан холбоо, хамтын ажиллагаа ойлголцол, дутагдалтай тал нөлөөлсөн гэж үзэж байна.

Монгол улсын гамшигаас хамгаалах хуулийн /7.3.5.оюутан, сурагчдын гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг тухайн сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасны үндсэн дээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/;

*/Энэ заалтад 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

суралцагцдын гамшигаас хамгаалах боловсрол олгох сургалтыг тухайн сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасны үндсэн дээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах гэсэн заалтыг хэрэгжүүлэх шаардлагтай болж байна.

Өнөөгийн байдлаар НҮБХХ-н орон нутгийн түвшинд гамшигийн эрсдэлийг бууруулах менежмент зохицуулалтын чадавхийг сайжруулах нь төслийн

дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх болон ЕБС-н 2, 3, 4, 6, 7, 8, 10, 11 дүгээр ангийн сурагчдад "Аюулгүй амьдрах ухааны үндэс" гарын авлагын ном, их дээд сургууль, коллежийн оюутануудад "Гамшигаас хамгаалах менежментийн үндэс" сурах бичгийг боловсруулан бэлэн болгожээ.

Зураг 3. ЕБС гамшгаас хамгаалах сургалт



Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв нь болзошгүй гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах болон аврах мэдлэг, дадлыг иргэд, олон нийтэд олгож, сургалтанд хамруулдаг юм.

Газар хөдлөлтийн гамшгийн зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, обьектыг орхин хэрхэн аюулгүй орчинд гарах, өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглаж сурах зэрэг иргэдийн мэдвэл зохих анхан шатны мэдлэг, дадлыг олгодог юм.

Сургалтын төвд иргэдийг тогтмол сургалтанд хамруулахаас гадна, ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг үе шаттайгаар сургалтанд хамруулж, анхан шатны мэдлэг олгох нь зүйтэй.

Гамшгаас хамгаалах сургалтын төвийн барилга нь Газар хөдлөлтийн танхим, Өндрөөс аврах ажиллагаа үзүүлэх танхим, Утаат орчны дадлага хийх, Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сургалтын танхим, 150 хүний багтаамж бүхий үзвэрийн 3D бичил кино театр, Нийслэлийн Онцгой комиссын хуралдааны танхим зэрэг нийт 5 өрөөтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээрхээс авч үзвэл "Зөв монгол хүүхэд", "Сургуулийн цөм хөтөлбөр", "Гамшгаас хамгаалах сургалт" гэх зэргийг явуулж байгаа боловч өнөөгийн нийгэмд зайлшгүй шаардлагатай байгаа MNS4969:2000 стандарттай бүрэн уялдуулж өгөөгүй, эцэг эхийн талаас хүүхэддээ олгож байгаа зөв дадал нь хангалтгүй байгаа нь харагдаж байна.

## 2.4 СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХАБЭА-Н СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ГАДААДЫН ТУРШЛАГА

1. АНУ–ын Хүний оюуны чадавхийг хөгжүүлэх хүрээлэн (The Institute for The Achievement of Human Potential (IAHP)). Энэ нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд хүүхдийн сэтгэхүйг бага наснаас нь хөгжүүлэх чиглэлээр судалгааны ажил явуулдаг.

2. ОХУ дахь эрүүл ба авъяаслаг хүүхдийг төлөвшүүлэх “Сонатал” төв.

3. Канадад “The Nation’s Leader in Child Safety Education” хэмээх уриатай “Child Safe Canada” сургалтын төвд 4...8, 9–өөс дээш насны хүүхдийг эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн ба хувийн амьдрал, ахуйгаа зөв хөтлөх арга барилд сургах, хууль ёсыг дээдлэх үзэлд төлөвшүүлэх сургалтыг явуулдаг. Канадад “Хүүхдийн аюулгүй байдлын боловсрол” хэмээх ухагдахуун нэгэнт тогтож, энэ чиглэлээрх байгууллагууд нь үйл ажиллагаагаараа хошуучлахыг эрхэм зорилго, уриагаа болгосон байгаа нь харагдаж байна.

4 .Мөн баруун европын орнууд, Япон, Хятадад хүүхдийг бага наснаас нь эрүүл саруул бие бялдартай, зөв сэтгэхүйтэй, зөв ажилладаг дадал хэвшилтэй болгон төлөвшүүлэх, хүмүүжүүлэх шинжлэх ухааны үндсийг өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлж түүний үр дүнд улс орны хөгжил нь дэлхийд тэргүүлэх эгнээнд хүрчээ.

Эдгээр оронд хүүхдийг амьдралын зөв дадал хэвшилд сургахдаа үндсэн 10 арга зүйг эрхэмлэдэг байх бөгөөд тэдгээрээс аюулгүй ажиллах арга барилд зан үйл болтол нь төлөвшүүлэх чухал 4 арга зүй нь:

- Зааж сургахдаа үйлдлээр үзүүлж түүнийгээ тайлбарлаж ойлгуулах нь илүү үр дүнтэй ба хүүхдийн сонирхлын дагуу жишээ татах хэрэгтэй.
- Гэнэтийн тохиололд хэн рүү хаашаа утсаар мэдэгдэх ёстойг зааж, тайлбарлаж өгөх
- Үл таних хүнээс юу ч авч болохгүй, дагаж явж болохгүйг тайлбарлах
- Тэжээвэр амьтдаас айх биш, харин орон зайнаас тэднийг хайрлах сэтгэлгээ төлөвшүүлэх.

## ХАБЭА-н сургалтын системийн ОХУ-н туршилгаас

ОХУ-д хүн амыг иргэний хамгаалалтын арга хэмжээнд сургахдаа, ард иргэд, албан хаагчид, мэргэжлийн ангийн бүрэлдхүүн, ерөхий боловсролын сургуулийн сурагчид, оюутанууд гэсэн ангилалаар жил бүр явуулж, нэгдсэн дадлага, сургалтанд хамруулдаг тогтолцоотой байна.

ОХУ-ын ЕБС-д "Основы безапасности жизнедеятельности" хичээлийн агуулагыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 4. ОХУ-н ЕБС-д ордог ХАБЭА-н талаарх хичээлийн агуулга

| I-р анги | II-р анги |
|---|---|
| • Гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй харьцах нь<br>• Утсаар хэрхэн ярих вэ?<br>• Замын өюулгүй байдалд хэрхэн оролцох вэ?<br>• Хотод төөрвөл яах вэ? | • Гэрт болон хөршийн гэрт гал гарвал яах вэ?<br>• Танихгүй хүн хаалга тогшвол яах вэ?<br>• Ойд төөрвөл яах вэ?<br>• Гол, ус газар зүйн аюулгүй байдал<br>• Хотын иргэдийн зөв амьдрал |
| **III-р анги** | **IV-р анги** |
| • Айдсаа даван туулах чадвар<br>• Хэрхэн зам хөндлөн гарах вэ?<br>• Халдвараас хэрхэн хамгаалах вэ?<br>• Ямар нөхцөлд гэмтэл тохиолддог вэ?<br>• Хэрвээ цус алдаж, шарх авбал яах вэ? | • Гэмтэхээс хамгаалах талаар<br>• Усан орчинд аюулгүй байдлыг хангах<br>• Тээврийн хэрэгсэл хэрхэн халдваргүйжүүлэх талаар<br>• Эрүүл мэнд |

Дээрх байдал нь сурагч хүүхдүүдэд багаас нь аюулгүй амьдрах үндсийг судлуулж, цэргийн албаны анхан шатны мэдлэг олгож, улс орноо батлан хамгаалах ойлголт өгөхөд анхаардаг байна.

ОХУ-д бүрэн ба бүрэн бус дунд сургуулиудад заах хөдөлмөрийн аюулгүй байдлын хичээлийн стандарт , энэ хичээлийн сургалтын онол, арга зүй боловсруулагдан хэрэгжиж байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Монгол улсын иргэн нь шат шатны түвшинд сурч боловсрох явцдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтаар эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйл дадалыг эзэмшсэн байх ёстой. Энэ нь Монгол улсын Стандарт хэмжилзүйн үндэсний төвөөс 2000 оны 06 дугаар сарын 27ний 105 тоот тогтоолоор батлан гаргасан MNS 4969:2000 стандартын 2.1 болон 2.2 зүйлд тус тус заасан байдаг. Сургуулийн өмнөх боловсрол болон ЕБС-д аюулгүй ажиллагааны анхан шатны дүрмийг бүтэн агууллагаар нь ордог хичээл байхгүй ч ерөнхий агуулгаар нь тусган ордог, хүүхдийг эрүүл аюулгүй өсгөж бойжуулах үүднээс аймгийн хэмжээнд маш олон арга хэмжээг зохион байгуулдаг ба эдгээр үйл ажиллагааг явуулж эхэлснээс хойш урьд урьдны жилүүдийг бодвол осол буурах хандлагтай байгаа нь үнэхээр сайшаалтай зүйл юм. Хүүхэд сургуулийн орчинд аюулгүй ажиллагааг сурч байгаа хэдий ч гэр бүлийн орчинд очихоор эцэг эхийн талаас энэ тал дээр гаргах хандлага тийм ч сайн биш тиймээс сургууль, гэр бүлийн хоорондох уялдаа холбоо сайн болгож багш эцэг эхийн холбоог сайжруулах нь зүйтэй юм.

# САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Эцэг эх асран хамгаалагчид болон багш нараас авсан судалгаанаас харвал судалгаанд оролцогчидын 60% нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг ухагдахууныг ойлголтгүй байгаа тул багш, эцэг эх сурган хүмүүжүүлэгчдийг ХАБЭА-н сургалтанд сургаж хандлагын өөрчлөх.
2. Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр энэ чиглэлээр боловсрол олгох.
3. Залуу эцэг эхчүүдэд зориулсан “Аюулгүй ажиллагааны зөвлөмж” гаргасан.

# НОМ ЗҮЙ

**Монгол ном**

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" Ч. Авдай 2008 он

"ХАБЭА-н гарын авлага" Л.Удвал 2013 он

**Цахим хаяг:**

www.google.mn

www.legalinfo.mn

www.slideshare.net

www.safetyfirts.mn

www.news.mn

www.edub.edu.mn

www.ntorc.mn

www.hema.gov.mn

www.estandart.mn

# ХАВСРАЛТ

## Багшаас асуух асуулга

| Асуулга | Хариулт |
|---|---|
| 1. Та аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэр сайн мэдэх вэ? | А. Мэднэ- 10%<br>Б. Мэдэхгүй- 60%<br>В. Бага зэрэг- 30% |
| 2. Таны бодлоор бага насны хүүхэд аюулд өртөх тохиолдол хэр их байдаг вэ? | А. Маш их -60%<br>Б. Их -40%<br>В. Бага -0% |
| 3. Та эрүүл аюулгүй байдлын талаар хичээл ордог уу? /үгүй бол яагаад?/ | А. Тийм - 10%<br>Б. Үгүй – 90%<br>Энэ нь сургалтын тогтолцоонд тусгагдаагүй |
| 4. Аюулгүй байдлын хичээлээ ямар байдлаар ордог вэ? /сургалтын хэлбэр/ | А. Ярилцлага- 90%<br>Б. Хөгжөөнт тоглоомоор- 10% |
| 5. Ямар хичээл дээр энэ талаар түлхүү ордог вэ? | Хүн байгаль, Хүн нийгэм |
| 6. Та хичээлээ өдөр бүр ордог уу? | А. Тийм- 35%<br>Б. Үгүй – 65% |

## Эцэг эхчүүдээс асуух асуумж

| Асуулга | Хариулт |
|---|---|
| 1. Та хэдэн хүүхэдтэй вэ? | /1-2/ хүүхэдтэй |
| 2. Таны хүүхэд хэдэн настай вэ?. | /3-8/ настай |
| 3. Та хүүхдийнхээ багштай хэр сайн харилцаатай вэ? | А. Сайн- 77%<br>Б. Дунд- 20%<br>В. Муу-3% |
| 4. Танай гэрээс танай хүүхдийн цэцэрлэг, сургууль хүртэлх хэр их эрсдэл байж болох вэ? /машин зам, гүүр, гол, ус, ШТС г.м/ | А. Эрсдэл ихтэй- 63%<br>Б. Эрсдэл багатай- 27% |
| 5. Та бага насны хүүхдээ аюултай эрсдэлтэй зүйлсээс хамгаалахын тулд ямар арга хэрглэдэг вэ? | А. Зааж зөвлөх- 50%<br>Б. Байнгын хараа хяналттай байлгах 50% |
| 6.Та хүүхдээ хараа хяналтгүй орхидог уу? | А. Тийм-0%<br>Б.Үгүй- 90%<br>В. Зарим тохиолдолд- 10% |
| 7. Та аюултай, эрсдэлтэй зүйлсийг хүүхэддээ хэрхэн ойлгуулдаг вэ? | А. Ярилцах- 40%<br>Б. зааж өгөх- 37%<br>В. эрсдэлийг өөрийн биеэр үзүүлэх- 23% |
| 8. Таны хүүхэд өмнө нь ахуйн осолд өртөж байсан уу? | А. Тийм- 45%<br>Б. Үгүй – 55% |
| 9. Та хүүхэддээ хэр их цаг зав гаргадаг вэ? | А. Сайн- 28%<br>Б. Муу-16%<br>В. Дунд- 56% |

## Бага насны хүүхдүүдтэй хийх ярилцлагын асуумж

1. Танай гэр танай сургуулиас хэр хол вэ?
2. Хичээлээс тархад нь ээж аав нь ирж авдаг уу?
3. Хичээл нь хэдэн цагаас тардаг вэ?
4. Чиний хувьд аюултай зүйл гэж юу вэ?
5. Найз чинь гүйж байгаад бүдрээд уначихвал чи яаж туслах вэ?

## ГРАФИКЫН ЖАГСААЛТ


| Дугаар | Графикийн нэр | Хуудасны тоо |
|---|---|---|
| График 1 | 2010-2015 оны хооронд улсын хэмжээнд гарсан зам тээврийн осол | 23 |
| График 2 | Говьсүмбэр аймгийн хэмжээнд гарсан осол гэмт хэрэг | 24 |
| График 3 | Түлэгдэлтийн нас баралт | 25 |
| График 4 | Говьсүмбэр аймгийн хэмжээнд гарсан түлэгдэлт | 27 |
| График 5 | Түлэгдэлтийн нас баралт | 27 |
| График 6 | Хүүхдүүдийн ярилцлага асуулгын хариулт | 30 |


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


| Дугаар | Зургын жагсаалт | Хуудасны тоо |
|---|---|---|
| Зураг 1 | Зам тээврийн ослын насжилт | 21 |
| Зураг 2 | ЕБС-н бага ангид ордог ном | 30 |
| Зураг 3 | ЕБС-н гамшгаас хамгаалах сургалт | 32 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| Дугаар | Хүснэгтийн нэр | Хуудасны тоо |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Асуулга 1 | 27 |
| Хүснэгт 2 | Асуулга 2 | 28 |
| Хүснэгт 3 | ЕБС-н сургалтын цөм хөтөлбөрийн чиглэл | 32 |
| Хүснэгт 4 | ОХУ-н ЕБС-д ХАБЭА-н хичээлийн агуулга | 41 |
| Хүснэгт 5 | Монгол улсын ЕБС-н бага ангид ордог хичээлийн агуулга | 34 |

### Осол гэмтэл

Нийтийн зам харгуй дээр тээврийн хэрэгсэлийн оролцоотойгоор гарах гэмтэл золгүй тохиолдолыг зам тээврийн осол гэнэ. **Тээврийн** хэрэгсэлээр зорчихдоо суудлын даруулга, бэхэлгээ хэрэглэснээр зорчигч, жолоочийн биед учрах осол гэмтэлийг бууруулж, урьдчилан сэргийлэх болно.

**Түлэгдэлт** буюу дулааны өндөр хэмээс шалтгаалах осол гэмтэл гэдэг нь халуун шингэн /шалзлах/, халуун хатуу биет /хавьталтын түлэгдэлт/, галын түлэгдэлтийн улмаас хүний арьсны давхрага хэсэгчлэн болон бүтэн гэмтэж болно. Химийн хорт бодисоор амьсгалснаас шалтгаалан уушги гэмтэх мөн химийн бодисын улмаас амны хөндий, хоол боловсруулах салст гэмтэхийг түлэгдэлд хамруулан авч үзнэ.

**Живэх** гэдэг нь шингэн зүйл амьсгалын замаар орж, амьсгал боогдуулахыг, **Хордолт** гэдэг нь хор болон бусад /эм, эрүүл бус хоол/ хорт зүйлийн нөлөөлөлөөс үүсэж байгаа үйл ажиллагааны өөрчлөлтийг тус тус хэлнэ.











### Түлэгдэлтийн үед дараах зүйлсийг хийж болохгүй

| **Хэзээ ч хийж болохгүй** | **Шинжлэх ухааны үндэслэл тайлбар** |
|---|---|
| Барааны саван | Хүйтэн гадаргуугаар хүрдэг учир өвдөлт түр намдаж байгаа мэт санагдана. |
| Элсэн чихэр | Бактери, нян нь чихэрлэг орчинд үрдэг. Иймд нянгийн тоог нэмэгдүүлэх болно. |
| Хоромхон тос | Өнгөц түлэгдэлтэнд хэрглэдэг. |
| Хорын цаас | Дулааны түлэгдэлтийг химийн түлэгдэлт болон хувиргадаг. |
| Уушигны улаан эм | Бактери, нянд тэсвэртэй шархыг бий болгодог. Түлэгдэлтийн улмаас хүнд үүсэх хордлогыг гүнзгийрүүлдэг. |